

**СОНСГОЛОН БАРМАТ ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026оны 4-р сар 30 ныөдөр

Дугаар 1.

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Сонсголон бармат” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн 10.00 минутанд Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 20 дугаар хороо, Сонсголон зам-75 компанийн өөрийн байранд 10 цагт болов.

Хуралд :

С.Сүхбаатар 482431 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

С.Сүхтөмөр 367156 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

С.Соёмбо 140611 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

С.Оюунцэцэг 274011 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

С.Номин 198801 ширхэг хувьцааны саналаар / өөрийн биеэр/

Сүхтөгс 437053 ширхэг хувьцааны саналаар / өөрийн биеэр/

ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 98.7 % хувийг эзэмшигчид болон тооллогын комиссын дарга гишүүд хуралд оролцлоо.

Хурлыг С. Оюунцэцэг удирдав.

Хурлаар:

- Компаны 2025 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулалын хэмжээг тогтоох;
- Компаний дүрмэнд өөрчлөлт оруулах төсөлийг хэлэлцүүлж батлах
- Бусад асуудал

асуудлыг тус тус хэлэлцэв.

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Д.Ариунбаатар хурлын ирцийг тодруулж, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 98.7 % хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69.1 д заасаны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэх зөвшөөрлийг хурлын даргад өгөв.

Хурал 10.20 минутанд эхлэв.

СОНССОН НЬ

- Хурлын дарга : Энэ хурал дэлхийн нийтэд эдийн засаг хямарч байгаа үед болж байна. Ингээд хэлэлцэх асуудлыг уншиж танилцуулья.

- Компаны 2025 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулалын хэмжээг тогтоох;
- Компаний дүрмэнд өөрчлөлт оруулах төсөлийг хэлэлцэж батлах

Бусад асуудал

Хэлэлцэх асуудлын дагуу **Хурлын дарга С.Оюунцэцэг:** 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлт, 2025 онд ногдол ашиг хуваарилахгүй байх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Оюунцэцэг: ТУЗ-ийн тайланг гишүүдэд хүргэсэн.

Компани нефть импортлогч 2 холбооны 10 гаруй гишүүн компаниудтай өөрийн салбар төмөр замд вагон тавих гэрээ хийж ажиллаж байхад 2025 оны 6-р сараас эхлэн нефтийн хямрал эхэлсэний улмаас манай замд вагон тавих асуудал гацсан. Үүнээс болж компаний орлого урьд онуудаас 2 дахин буурсан.

-ТУЗ гишүүдийг улируулан сонгох саналтай байна.

Хурлын дарга С.Оюунцэцэг: -Компанийн үйл ажилгааны чиглэл өөрчлөгдсөний улмаас

Компаний тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор компаний дүрэмд өөрчлөлт оруулж улсын бүртгэлийн газар бүртгүүлэх шаардлага тавьсан тул энэ асуудлыг яаралтай шийдвэрлэх хэрэгтэй байна. Компаний дүрмэнд өөрчлөлт оруулах асуудлаар ТУЗ-ийн гишүүд ажиллаж төслийг бэлдэж урьдчилан гишүүдэд хүргэсэн, бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж батлуулах хэрэгтэй. Хэнд ямар санал байна.

Оюунцэцэг : ТУЗ-ийн гишүүн С.Сүхтөмөр, Сүхбаатар, нар компаний дүрмийн өөрчлөлт дээр сар шахуу ажилласан. Асууж тодруулах зүйл байвал харриулья

Ариунсайн: Энэ шинэчилсэн дүрэм нь.СЗХ-ноос гаргасан загвар дүрмийг баримталж хийсэн дүрэм тул сайн боловсруулагдсан, манай ихэнх компани мөрдөж байгаа дүрэм болоно.

Хуралд оролцогсод дэмжиж батлав.

Хувьцаа эзэмшигч С.Соёмбо : Төмөр замтай талбайд Гаалийн баталгаат агуулах барих , үүний тулд талбайг бетондох, контейнер өргөх, буулгах зориулалтын кран тавих асууул ямар шатанд явж байгаа бэ.?

Захирал Сүхбаатар: Ойролцоогоор 3 га талбай арматураар хүчитгэж бетондоход 10 тэрбум төгрөгийн зардал гарах тооцоо гарсаны улмаас уг төсөл одоогоор хэрэгжих боломжгүй байна. Хамтрах байгууллага хайж байгаа.

Хурлын дарга С.Оюунцэцэг: За хэсэг засарлаад саналаа хураая

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2025 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсаныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.
4. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. С.Сүхбаатар
2. С.Сүхтөгс
3. С. Соёмбо
4. С.Сүхтөмөр
5. С.Оюунцэцэг
6. С.Номин

5. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Д. Ариунбаатар
2. Д.Ууганбаяр
3. Б. Пүрэвжал

6. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

7..Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшуулалын төсвийг хавсралт № 01 тоотой баталсугай.

8. Батлагдсан төсвийг дагуу цалин урамшуулалыг бодож олгохыг нягтлан бодогчид даалгасугай

9. Компаний тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор компаний дүрэмд өөрчлөлт оруулж улсын бүртгэлийн газар бүртгүүлэх шаардлагын дагуу компаний дүрмийг өөрчилж зассан төслийг баталсугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 11 цаг 40 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



[Signature]

/С.Оюунцэцэг/

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

[Signature]

/Д.АРИУНБААТАР/